

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/037/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ц.Уртнасан Утас: 7036-2442 Цахим хаяг: urtaa6969@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Seelenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.08.25 № СЭА-2026/237/НН-СЭА-043
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ТУУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 9,398.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 1 дүгээр цэцэрлэг нь тайлант онд 5 зорилт, 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 94.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	329,808,932.22	148,331,023.57
2	31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	242,874,525.04	47,170,741.87
3	31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	242,874,525.04	47,170,741.87
4	31210	Төгрөг	242,874,525.04	47,170,741.87
5	31211	Төрийн сангийн харилцах	242,874,525.04	47,170,741.87
6	33	АВЛАГА	59,225.48	0
7	33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	59,225.48	0
8	35	БАРАА МАТЕРИАЛ	86,875,181.70	101,160,281.70
9	35100	Түүхий эд материал	660,000.00	660,000.00
10	35110	Тусгай зориулалттай материал	660,000.00	660,000.00
11	35400	Хангамжийн материал	86,215,181.70	100,500,281.70
12	35410	Бичиг хэргийн материал	767,500.00	148,100.00
13	35420	Аж ахуйн материал	67,630,981.70	67,630,981.70
14	35460	Хүнсний материал	1,660,700.00	5,359,100.00
15	35470	Бусад хангамжийн материал	16,156,000.00	27,362,100.00
16	2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,203,334,094.00	3,153,046,660.20
17	39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,203,334,094.00	3,153,046,660.20
18	39200	Биет хөрөнгө	3,189,254,094.00	3,134,442,660.20
19	39201	Барилга, байгууламж, орон сууц	3,200,958,080.00	3,200,958,080.00
20	39202	Хуримтлагдсан элэгдэл	-171,972,923.39	-225,261,068.51
21	39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	93,981,687.00	93,237,087.00
22	39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,350,400.34	-8,250,689.70
23	39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,415,210.00	80,442,360.00
24	39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,603,146.33	-21,238,300.53
25	39209	Зам, гүүрийн байгууламж	42,811,200.00	42,811,200.00
26	39210	Хуримтлагдсан элэгдэл	-42,811,200.00	-42,811,200.00
27	39214	Бусад үндсэн хөрөнгө	22,718,400.00	22,718,400.00
28	39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,896,562.94	-8,166,958.06
29	39217	Ном	3,750.00	3,750.00
30	39300	Биет бус хөрөнгө	14,080,000.00	18,604,000.00
31	39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
32	39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	-250,000.00
33	39303	Бусад биет бус хөрөнгө	14,080,000.00	18,604,000.00
34	3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,533,143,026.22	3,301,377,683.77
35	5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,533,143,026.22	3,301,377,683.77
36	51	Засгийн газрын хувь оролцоо	3,533,143,026.22	3,301,377,683.77
37	51100	Засгийн газрын оруулсан капитал	215,688,467.50	215,688,467.50
38	511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	215,688,467.50	215,688,467.50
39	51200	Хуримтлагдсан үр дүн	3,135,829,470.52	2,884,537,078.07
40	51210	Өмнөх үеийн үр дүн	3,214,861,352.01	3,135,829,470.52
41	51220	Тайлант үеийн үр дүн	-79,031,881.49	-251,292,392.45
42	51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	181,625,088.20	201,152,138.20
43	6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,533,143,026.22	3,301,377,683.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,151,262,120.00	1,033,104,500.00
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,404,920.00	1,033,104,500.00
3	120	Нийтлэг татварын бус орлого	85,404,920.00	29,011,000.00
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	0
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	0
6	120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	84,404,920.00	8,833,700.00
7	120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	20,177,300.00
12	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,065,857,200.00	1,004,093,500.00
13	1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,065,857,200.00	1,004,093,500.00
14	131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,065,857,200.00	1,004,093,500.00
15	II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,106,140,034.90	1,284,396,892.45
16	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,106,140,034.90	1,284,396,892.45
17	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,095,940,934.90	1,278,287,692.45
18	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	750,481,542.79	922,809,803.36
19	210101	Үндсэн цалин	497,812,146.00	591,375,004.38
20	210102	Нэмэгдэл	223,859,956.79	270,453,988.98
21	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	27,420,000.00
22	210104	Урамшуулал	28,809,440.00	33,560,810.00
23	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,194,717.30	115,427,105.29
24	210201	Тэтгэврийн даатгалын зардал	60,680,451.48	79,305,019.27
25	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	11,942,650.45	9,296,503.46
26	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,307,881.39	4,573,161.99
27	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,052,193.38	4,439,967.16
28	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	14,211,540.60	17,812,453.41
29	2104	Хангамж, бараа материалын зардал	2,886,750.00	13,802,602.00
30	210401	Бичиг хэрэг	2,886,750.00	0
31	210402	Тээвэр, шатахуун	0	3,586,302.00
32	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	10,216,300.00
33	2105	Нормативт зардал	95,618,720.00	105,711,995.00
34	210502	Хоол, хүнс	95,618,720.00	105,711,995.00
35	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,455,000.00	2,839,000.00
36	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,455,000.00	2,839,000.00
37	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,304,204.81	117,697,186.80
38	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,351,480.00	21,711,803.00
39	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,308,299.80	11,357,400.00
40	210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,644,425.01	84,627,983.80
41	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,199,100.00	6,109,200.00
42	2132	Бусад урсгал шилжүүлэг	10,199,100.00	6,109,200.00

43	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,199,100.00	6,109,200.00
44	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	45,122,085.10	-251,292,392.45
45	V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	124,153,966.59	0
46	225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	124,153,966.59	0
47	VII	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-124,153,966.59	0
48	VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	-79,031,881.49	-251,292,392.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,066,857,200.00	1,004,093,500.00
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	1,004,093,500.00
3	120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	0
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	0
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	0
6	122	Тусламжийн орлого	0	1,004,093,500.00
7	1221	Хандив тусламж /дотоод/	0	1,004,093,500.00
8	12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0	1,004,093,500.00
9	122111	Урсгал санхүүжилтийн орлого	0	1,004,093,500.00
10	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,065,857,200.00	0
11	1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,065,857,200.00	0
12	131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,065,857,200.00	0
13	II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	985,594,815.37	1,199,797,283.17
14	21	УРСГАЛ ЗАРДАЛ	985,594,815.37	1,199,797,283.17
15	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	975,495,715.37	1,193,688,083.17
16	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	750,298,468.27	922,809,803.36
17	210101	Үндсэн цалин	497,629,071.48	559,532,228.41
18	210102	Нэмэгдэл	223,859,956.79	302,296,764.95
19	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	27,420,000.00
20	210104	Урамшуулал	28,809,440.00	33,560,810.00
21	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,194,717.30	115,367,879.81
22	210201	Тэтгэврийн даатгалын зардал	65,023,364.48	79,245,793.79
23	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	7,599,737.45	9,296,503.46
24	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,307,881.39	4,573,161.99
25	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,015,393.38	4,439,967.16
26	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	14,248,340.60	17,812,453.41
27	2105	Нормативт зардал	93,971,500.00	109,410,395.00
28	210502	Хоол, хүнс	93,971,500.00	109,410,395.00
29	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,570,000.00	2,759,000.00
30	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,570,000.00	2,759,000.00
31	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,461,029.80	43,341,005.00
32	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,364,330.00	32,603,005.00
33	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,096,699.80	10,738,000.00
34	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,099,100.00	6,109,200.00

35	2132	Бусад урсгал шилжүүлэг	10,099,100.00	6,109,200.00
36	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,099,100.00	6,109,200.00
37	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	81,262,384.63	-195,703,783.17
38	V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	5,572,000.00	0
39	22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,572,000.00	0
40	2200	Дотоод эх үүсвэрээр	5,572,000.00	0
41	225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,572,000.00	0
42	VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,572,000.00	0
43	VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	75,690,384.63	-195,703,783.17
44	101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	167,184,140.41	242,874,525.04
45	20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	242,874,525.04	47,170,741.87

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Данс-ны код	Дансны нэр, төрөл				
			1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	3,214,861,352.01	3,612,174,907.71
2	3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	3,214,861,352.01	3,612,174,907.71
3	9	Тайлант үеийн үр дүн	0	0	-79,031,881.49	-79,031,881.49
4	10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	3,135,829,470.52	3,533,143,026.22
5	11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	3,135,829,470.52	3,533,143,026.22
6	13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	215,688,467.50	181,625,088.20	3,135,829,470.52	3,533,143,026.22
7	14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	19,527,050.00	0	19,527,050.00
8	19	Тайлант үеийн үр дүн	0	0	-251,292,392.45	-251,292,392.45
9	20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	215,688,467.50	201,152,138.20	2,884,537,078.07	3,301,377,683.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан Улсын төсөв

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,008,170,900.00	1,004,093,500.00	4,077,400.00	99.6
2	12	Татварын бус орлого	1,008,170,900.00	1,004,093,500.00	4,077,400.00	99.6
3	122	Тусламжийн орлого	1,008,170,900.00	1,004,093,500.00	4,077,400.00	99.6
4	122005	Төсвөөс санхүүжих	1,008,170,900.00	1,004,093,500.00	4,077,400.00	99.6
5	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,233,799,500.00	1,199,797,283.17	34,002,216.83	97.2
6	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,233,799,500.00	1,199,797,283.17	34,002,216.83	97.2
7	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,227,690,300.00	1,193,688,083.17	34,002,216.83	97.2
8	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	948,887,200.00	922,809,803.36	26,077,396.64	97.3
9	210101	Үндсэн цалин	602,552,600.00	559,532,228.41	43,020,371.59	92.9
10	210102	Нэмэгдэл	314,901,700.00	302,296,764.95	12,604,935.05	96.0
11	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	27,420,000.00	-27,420,000.00	100.0
12	210104	Урамшуулал	31,432,900.00	33,560,810.00	-2,127,910.00	106.8
13	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,884,300.00	115,367,879.81	2,516,420.19	97.9
14	210201	Тэтгэврийн даатгал	80,027,300.00	79,245,793.79	781,506.21	99.0
15	210202	Тэтгэмжийн даатгал	9,464,300.00	9,296,503.46	167,796.54	98.2
16	210203	ҮОМШӨ-ний даатгал	4,732,100.00	4,573,161.99	158,938.01	96.6
17	210204	Ажилгүйдлийн даатгал	4,732,100.00	4,439,967.16	292,132.84	93.8
18	210205	Эрүүл мэндийн даатгал	18,928,500.00	17,812,453.41	1,116,046.59	94.1
19	2105	Нормативт зардал	113,028,000.00	109,410,395.00	3,617,605.00	96.8
20	210502	Хоол, хүнс	113,028,000.00	109,410,395.00	3,617,605.00	96.8
21	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,942,900.00	2,759,000.00	1,183,900.00	70.0
22	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,942,900.00	2,759,000.00	1,183,900.00	70.0
23	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,947,900.00	43,341,005.00	606,895.00	98.6
24	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,209,800.00	32,603,005.00	606,795.00	98.2
25	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,738,100.00	10,738,000.00	100.00	100.0
26	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,109,200.00	6,109,200.00	0.00	100.0
27	2132	Бусад урсгал шилжүүлэг	6,109,200.00	6,109,200.00	0.00	100.0
28	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,109,200.00	6,109,200.00	0.00	100.0
29	8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-225,628,600.00	-195,703,783.17	-29,924,816.83	86.7
30	9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	225,628,600.00	195,703,783.17	29,924,816.83	86.7
31	7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	225,628,600.00	195,703,783.17	29,924,816.83	86.7

32	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	242,874,525.04	-	242,874,525.04
33	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	47,170,741.87	-	-47,170,741.87

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан Орон нутгийн төсөв

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	103,876,400.00	91,301,354.34	12,575,045.66	87.89
12	Татварын бус орлого	103,876,400.00	91,301,354.34	12,575,045.66	87.89
122	Тусламжийн орлого	103,876,400.00	91,301,354.34	12,575,045.66	87.89
122005	Төсвөөс санхүүжих	103,876,400.00	91,301,354.34	12,575,045.66	87.89
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,876,400.00	91,301,354.34	12,575,045.66	87.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,876,400.00	91,301,354.34	12,575,045.66	87.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,876,400.00	91,301,354.34	12,575,045.66	87.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,562,400.00	79,002,054.34	12,560,345.66	86.28
210301	Гэрэл, цахилгаан	25,034,100.00	15,531,897.54	9,502,202.46	62.04
210302	Түлш, халаалт	62,442,300.00	59,570,156.80	2,872,143.20	95.40
210303	Цэвэр, бохир ус	4,086,000.00	3,900,000.00	186,000.00	95.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,314,000.00	12,299,300.00	14,700.00	99.88
210604	Урсгал засвар	12,314,000.00	12,299,300.00	14,700.00	99.88
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **5,114.8** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд хоолны 590.8 мянган төгрөгийг зардлын бараа үйлчилгээний бусад зардалд тайлагнасан.
- 4,524.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг орлогоор бүртгэхдээ дахин үнэлэгдсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнасан.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон

УСНББОУС-12 “*Бараа материал*”-ийн 16¹, УСНББОУС-17 “*Үндсэн хөрөнгө*”-ийн 13², Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “*Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*”-ын 3.4, 10.23, 10.26 дахь заалтууд болон “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар алдаа зөрчилийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөрчилд зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **611.2** мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 11,854.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Commented [OA1]: Дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлах

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Нормативт зардалтай холбоотой асуудал*

1.1 Илрүүлэлт: Хүүхдийн хоолны хүнсний материалыг олгохдоо насны ялгавартай нормативын дагуу тооцож олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 сарын 2 өдрийн А/166 / А/559/ 222 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г тогтоосон тушаалыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхдийн хоолны хүнсний материалыг батлагдсан нормативын дагуу насны ялгавартайгаар тооцож олгох зөвлөмж хүргүүлээ.

2. *Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал төлөвлөх, хуваарилахтай холбоотой асуудал:*

2.1 Илрүүлэлт: Тус цэцэрлэг нь хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал төлөвлөх, хуваарилах ажлын хэсгийг байгуулаагүй бөгөөд батлагдсан заавар журмын дагуу ажиллаагүй байна.

Энэ нь Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/279 дүгээр тушаалаар баталсан “Заавар шинэчилэн батлах тухай” тушаалын 1-р хавралтын 3.3. дахь “*Энэ зааврын 3.2-т заасан хуваарийн дагуу сургалтад ашиглах материал, хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, мэргэжлийн багш нарын бүлгийн ахлагчид хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий*

¹ Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ.

² Элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм, ашиглалтын хугацаа гэдэг нь а)байгууллагад уг хөрөнгө ашиглагдах боломжтой байхаар хүлээгдэж буй хугацаа,

таваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг цэцэрлэгийн эрхлэгч/сургуулийн захирлын тушаалаар томилон ажиллуулна” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах материал, хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, ажлын хэсгийг томилон зааврын дагуу ажилуулах зөвлөмж хүргүүлээ.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд хоолны зардлын бараа үйлчилгээний бусад зардалд тайлагнасан	1	590.8			1	590.8	1	590.8				
Биет бус хөрөнгийг орлогоор бүртгэхдээ дахин үнэлэгдсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнасан	1	4,524.0			1	4,524.0	1	4,524.0				
Урамшууллын суутгалыг суутган тооцооллын тайланд тайлагнаагүй, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орогын дансанд шилжүүлэн	1	611.2			1	611.2			1	611.2		
Дүн	2	5,726.0			2	5,114.8	2	5,114.8	1	611.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал-тны тоо	Тоо	Дүн
Хүүхдийн хоолны хүнсний материалыг олгохдоо насны ялгавартай нормативын дагуу тооцож олгох							1	0				
Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал төлөвлөх, хуваарилах ажлын хэсгийг байгуулж, зааврын дагуу ажиллуулах							1	0				
Дүн	1	611.2	1	611.2	1	611.2	2	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тус цэцэрлэг нь 6 мэдээллийг огт шивээгүй 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн								1	0
Нийт								1	0

